



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/88/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Аудитор: Б.Азжаргал
Утас: 70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа	15
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 62

танай _____-ны № _____-т

ЖАРГАЛАНТ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ц.ДЭЛГЭРМАА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл аудитлагдаагүй	Эцсийн үлдэгдэл аудитлагдсан
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>85,463,228.05</u>	<u>85,463,228.05</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,572,509.73	10,572,509.73
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	10,572,509.73	10,572,509.73
31211	Төрийн сангийн харилцах	292,959.73	292,959.73
31215	Нэмэлт санхүүжилтийн	10,279,550.00	10,279,550.00
33	АВЛАГА	49,680,377.76	49,680,377.76
33300	Татаас, санхүүжилтийн авлага	49,314,000.00	49,314,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	366,377.76	366,377.76
35	БАРАА МАТЕРИАЛ	25,210,340.56	25,210,340.56
351	Түүхий эд материал	19,370,432.56	19,370,432.56
35110	Тусгай зориулалттай материал	7,883,535.00	7883535
35130	Эм боох материал	11,486,897.56	11,486,897.56
354	Хангамжийн материал	5,839,908.00	5,839,908.00
35410	Бичиг хэргийн материал	29,000.00	29,000.00
35420	Аж ахуйн материал	1,533,500.00	1,533,500.00
35440	Түлш, шатах тослох материал	1,690,000.00	1,690,000.00
35450	Барилгын засварын материал	1,258,000.00	1,258,000.00
35460	Хүнсний материал	127,108.00	127,108.00
35470	Бусад хангамжийн материал	1,202,300.00	1,202,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>356,235,610.51</u>	<u>356,235,610.51</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	356,235,610.51	356,235,610.51
392	Биет хөрөнгө	351,567,610.51	351,567,610.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	135,973,835.18	135,973,835.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,325,735.83)	(33,325,735.83)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,730,000.00	89,730,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(62,084,861.12)	(62,084,861.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	320,342,094.80	320,342,094.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(135,197,438.05)	(135,197,438.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,328,088.00	34,328,088.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,856,398.33)	(21,856,398.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,542,301.08	25,542,301.08
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,884,275.22)	(1,884,275.22)
393	Биет бус хөрөнгө	4,668,000.00	4,668,000.00
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(825,000.00)	(825,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,668,000.00	4,668,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>441,698,838.56</u>	<u>441,698,838.56</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>49,314,000.00</u>	<u>49,314,000.00</u>

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	49,314,000.00	49,314,000.00
413	Өглөг	49,314,000.00	49,314,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	18,664,893.00	18,664,893.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	27,544,007.00	27,544,007.00
4136	Бусад өглөг	3,105,100.00	3,105,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	392,384,838.56	392,384,838.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,132,680.00	164,132,680.00
	Дахин үнэлгээний нөөц	154,246,268.01	154,246,268.01
512	Хуримтлагдсан үр дүн	74,005,890.55	74,005,890.55
51210	Өмнөх үеийн үр дүн	(90,643,706.12)	(90,643,706.12)
51220	Тайлант үеийн үр дүн	164,649,596.67	164,649,596.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>441,698,838.56</u>	<u>441,698,838.56</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Аудитлагдсан	Аудитлагдаагүй
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	935,228,383.96	935,228,383.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	262,818,375.76	262,818,375.76
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	262,818,375.76	262,818,375.76
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,747,400.00	170,747,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	170,747,400.00	170,747,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,538,800.00	21,538,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,538,800.00	21,538,800.00
1330	Төсвийн захирагчдаас	433,131,600.00	433,131,600.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	433,131,600.00	433,131,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	46,992,208.20	46,992,208.20
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	16,967,658.20	16,967,658.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,024,550.00	30,024,550.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	770,569,662.42	770,569,662.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	770,569,662.42	770,569,662.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	394,919,354.27	394,919,354.27
210101	Үндсэн цалин	208,738,793.27	208,738,793.27
210102	Нэмэгдэл	148,772,861.00	148,772,861.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,048,000.00	6,048,000.00
210104	Урамшуулал	31,359,700.00	31,359,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,200,281.00	51,200,281.00
210201	Тэтгэврийн даатгал	37,905,381.00	37,905,381.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,890,200.00	2,890,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,774,600.00	2,774,600.00

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	693,600.00	693,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,936,500.00	6,936,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,020,000.00	16,020,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,616,522.00	4,616,522.00
210302	Түлш, халаалт	10,628,100.00	10,628,100.00
210303	Цэвэр, бохир ус	775,378.00	775,378.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,669,150.00	29,669,150.00
210401	Бичиг хэрэг	3,238,420.00	3,238,420.00
210402	Тээвэр, шатахуун	18,829,550.00	18,829,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,003,630.00	1,003,630.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,860,630.00	1,860,630.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,736,920.00	4,736,920.00
2105	Нормативт зардал	155,858,235.03	155,858,235.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	146,811,675.03	146,811,675.03
210502	Хоол, хүнс	7,848,860.00	7,848,860.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,197,700.00	1,197,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,650,592.00	13,650,592.00
210604	Урсгал засвар	13,650,592.00	13,650,592.00
2107	Томилолт, зочны зардал	1,499,800.00	1,499,800.00
210702	Дотоод албан томилолт	1,499,800.00	1,499,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,509,648.00	1,509,648.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,080,000.00	1,080,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,728.00	104,728.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	278,240.00	278,240.00
210807	Газрын төлбөр	46,680.00	46,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,774,943.92	50,774,943.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,776,850.00	3,776,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,998,093.92	46,998,093.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,467,658.20	55,467,658.20
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	16,967,658.20	16,967,658.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,500,000.00	38,500,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	164,658,721.54	164,658,721.54
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,124.87	9,124.87
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,124.87	9,124.87
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(9,124.87)	(9,124.87)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	164,649,596.67	164,649,596.67

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

АУДИТЛАГДЛАГДСАН

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,132,680.00	154,246,268.01	(97,840,623.40)	220,538,324.61
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	164,132,680.00	154,246,268.01	(97,840,623.40)	220,538,324.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			7,196,917.28	7,196,917.28
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,132,680.00	154,246,268.01	(90,643,706.12)	227,735,241.89
D08	Тайлант үеийн үр дүн			164,649,596.67	164,649,596.67
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,132,680.00	154,246,268.01	74,005,890.55	392,384,838.56

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Аудитлагдсан	Аудитлагдаагүй
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>626,692,008.20</u>	<u>626,692,008.20</u>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	96,000.00	96,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	96,000.00	96,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	124,933,400.00	124,933,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	124,933,400.00	124,933,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,538,800.00	21,538,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,538,800.00	21,538,800.00
1330	Төсвийн захирагчдаас	433,131,600.00	433,131,600.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	433,131,600.00	433,131,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	46,992,208.20	46,992,208.20
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	16,967,658.20	16,967,658.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,024,550.00	30,024,550.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	616,119,498.47	616,119,498.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	616,119,498.47	616,119,498.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	381,828,338.27	381,828,338.27
210101	Үндсэн цалин	213,975,567.38	213,975,567.38
210102	Нэмэгдэл	135,400,920.38	135,400,920.38

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,118,981.00	5,118,981.00
210104	Урамшуулал	27,332,869.51	27,332,869.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,126,404.00	49,126,404.00
210201	Тэтгэврийн даатгал	35,253,504.00	35,253,504.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,468,200.00	3,468,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,774,600.00	2,774,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	693,600.00	693,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,936,500.00	6,936,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,020,000.00	16,020,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,616,522.00	4,616,522.00
210302	Түлш, халаалт	10,628,100.00	10,628,100.00
210303	Цэвэр, бохир ус	775,378.00	775,378.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,316,550.00	26,316,550.00
210401	Бичиг хэрэг	3,017,420.00	3,017,420.00
210402	Тээвэр, шатахуун	17,019,550.00	17,019,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,003,630.00	1,003,630.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,860,630.00	1,860,630.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,415,320.00	3,415,320.00
2105	Нормативт зардал	73,710,000.00	73,710,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	63,510,000.00	63,510,000.00
210502	Хоол, хүнс	7,800,000.00	7,800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,400,000.00	2,400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,641,100.00	7,641,100.00
210604	Урсгал засвар	7,641,100.00	7,641,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,499,800.00	1,499,800.00
210702	Дотоод албан томилолт	1,499,800.00	1,499,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,509,648.00	1,509,648.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,080,000.00	1,080,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	382,968.00	382,968.00
210807	Газрын төлбөр	46,680.00	46,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,467,658.20	55,467,658.20
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	16,967,658.20	16,967,658.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,500,000.00	38,500,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>10,572,509.73</u>	<u>10,572,509.73</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	10,572,509.73	10,572,509.73
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,572,509.73	10,572,509.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	484,579,300.00	484,497,990.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	484,579,300.00	484,497,990.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	482,779,300.00	482,697,990.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,823,500.00	346,916,042.27
210101	Үндсэн цалин	209,064,700.00	213,975,567.38
210102	Нэмэгдэл	100,351,100.00	100,488,624.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,048,000.00	5,118,981.00
210104	Урамшуулал	31,359,700.00	27,332,869.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,822,400.00	46,648,700.00
210201	Тэтгэврийн даатгал	32,949,500.00	32,775,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,468,200.00	3,468,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,774,600.00	2,774,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	693,600.00	693,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,936,500.00	6,936,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,019,300.00	16,020,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,066,800.00	4,616,522.00
210302	Түлш, халаалт	10,109,100.00	10,628,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,843,400.00	775,378.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,240,000.00	20,897,000.00
210401	Бичиг хэрэг	2,520,000.00	2,517,420.00
210402	Тээвэр, шатахуун	12,600,000.00	12,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,320,000.00	1,003,630.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,400,000.00	1,860,630.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,000.00	2,915,320.00
2105	Нормативт зардал	41,400,000.00	41,400,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,200,000.00	31,200,000.00
210502	Хоол, хүнс	7,800,000.00	7,800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,400,000.00	2,400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,518,800.00	5,518,800.00
210604	Урсгал засвар	5,518,800.00	5,518,800.00
2107	Томилолт, зочны зардал	788,600.00	787,800.00
210702	Дотоод албан томилолт	788,600.00	787,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,166,700.00	1,509,648.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,080,000.00	1,080,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	382,968.00
210807	Газрын төлбөр	46,700.00	46,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,800,000.00	1,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	1,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	1,800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	484,578,000.00	484,790,950.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	433,131,600.00	433,131,600.00

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	433,131,600.00	433,131,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,538,800.00	21,538,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	21,538,800.00	21,538,800.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,907,600.00	30,024,550.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	29,907,600.00	30,024,550.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	96,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	96,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		292,959.73
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	114,653,850.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	114,653,850.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,953,850.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,912,296.00
210102	Нэмэгдэл	34,912,296.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,477,704.00
210201	Тэтгэврийн даатгал	2,477,704.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,419,550.00
210401	Бичиг хэрэг	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,419,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00
2105	Нормативт зардал	32,310,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,310,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,122,300.00
210604	Урсгал засвар	2,122,300.00
2107	Томилолт, зочны зардал	712,000.00
210702	Дотоод албан томилолт	712,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,700,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,700,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	124,933,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	124,933,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,933,400.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,279,550.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын Эрүүл мэндийн төв нь шуурхай чанартай, хүртээмжтэй тусламж үйлчилгээг чадварлаг мэргэшсэн хамт олон, шинэ санаа зөв арга барилаар, харилцаа хамтын ажиллагааны үндсэн дээр эрүүл мэндийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх зорилго бүхий Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХууль тогтоомжид өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн, төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв болох 484,579.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,268.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,451.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад өөрчлөөгүй болно.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 210,463.6 мянган төгрөгөөр буюу 47.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	10,572.5	10,572.5
Бараа материал	23,832.1	25,210.3	1,378.1
Үндсэн хөрөнгө	203,440.6	356,235.6	152,794.9
Авлага	3,500.0	49,314.0	45,814.0
Нийт хөрөнгө	231,235.2	441,698.8	210,463.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	231,235.2	441,698.8	210,463.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	231,235.2	441,698.8	210,463.6

Бараа материалын данс 25,210.3 мянган төгрөг болж 1,378.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, шатах тослох материал, засварын материал, хүнс, бусад хангамжийн материалууд үлдэгдэлтэй гарснаас шалтгаалсан байна. Энэ нь Ковид цар тахалтай холбоотой шатахуун, эм, ариутгал цэвэрлэгээний материалыг тодорхой хэмжээний нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 356,235.6 мянган төгрөг болж 152,794.9 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ-аас 58,075.1 мянган төгрөгийн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 118,784.0 мянган төгрөгийн, ОНХСангийн хөрөнгө оруулалтаар 22,945.0

мянган төгрөгийн үндсэн хөрөнгүүд бэлтгэгдэж ирсэн ба 3,383.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актлагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 441,698.8 төгрөг болж 210,463.6 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 363,565.1 мянган төгрөгөөр буюу 38.9 хувиар, нийт зардал өмнөх оноос 206,103.3 мянган төгрөгөөр буюу 26.8 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Жаргалант сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 681,731.8 мянган төгрөгөөр төлөвлөн, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэнээс 484,579.3 мянган төгрөгөөр батлагдан ирсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр 433,131.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн орлогоос 21,538.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 29,907.6 төгрөгөөр санхүүжихээр төлөвлөж, улсын төсвөөс 433,131.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 21,538.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 30,024.5 төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд нийт 484,497.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 484,497.9 мянган төгрөг буюу цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 346,916.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 46,648.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 16,020.0 мянган төгрөг, хангамжийн материалын зардалд 20,897.0 мянган төгрөг, норматив зардал 41,400.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 5,518.8 мянган төгрөг, томилолт зочны зардал 787.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 1,509.6 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 3,000.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардалд 1,800.0 мянган төгрөг зарцуулсан ба хэмнэгдсэн зардал болон давж биелсэн үндсэн үйл ажиллагааны орлого болох нийт 292.9 мянган төгрөгийг дансны үлдэгдэл болгон үлдээсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 150,161.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 111,125.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 49,314.0 мянган төгрөгийн дутуу санхүүжилт олгогдоогүй өглөг, авлага үүссэн байна. Энэ нь Орхон аймаг дахь ЭМД-ын хэлтэстэй хийсэн тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажиж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЭМД-ийн сангаас Ковидын дархлаажуулалт урьдчилан сэргийлэх, тандалт шинжилгээ хийх, гэрийн эмчилгээ тусгаарлалтын зардалд 81,101.4 мянган төгрөг төвлөрч, эрүүл мэндийн ажилтнуудад буцалтгүй тусламж дэмжлэг 36,200.0 мянган төгрөг, сүрьеэгийн үзлэг зохион байгуулах, сүрьеэгийн сорьц тээвэрлэх зардалд 1,716.0 мянган төгрөг зарцуулж, ЭМГ-аас эмнэлгийн ажилтны өдрийг тохиолдуулан олгосон 500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг хамт олны хурлаар хэлэцлэн, Ковид цар тахалын үед сайн ажилласан 2 эмчид урамшуулал хэлбэрээр олгосон байна.

Аймгийн ОБГ-аас 1,960.0 мянган төгрөгийн шатахуун, сумын ЗДТГ-с 1,000.0 мянган төгрөгийн шатахууны дэмжлэг үзүүлсэн ба тус бүрийн гүйцэтгэлд зарцуулагдсан байна.

ЭМД-ийн сангийн санхүүжилт 81,101.4 мянган төгрөгөөс ажилчдын илүү цаг, НДШ-ийн зардалд 37,390.0 мянган төгрөг, эмийн зардалд 32,310.0 мянган төгрөг, шатахуунд 1,900.0 мянган төгрөг, бичиг хэрэг, ТХ-ийн бэлэн байдлыг хангах зорилгоор сэлбэг хэрэгсэл болон урсгал засвар бусад зардалд 9,501.4 мянган төгрөг зарцуулагдсан байна.

2021 оны 10, 11, 12 сарын ЭМД-ийн санхүүжилт төсөв хүрэхгүй байгаа шалтгаанаар санхүүжилт олгогдоогүйгээс 49,300.0 мянган төгрөгийн өр авлага үүссэн ба энэ нь ажилчдын илүү цагийн хөлс болон НДШ-д 18,664.9 мянган төгрөг, эм эмнэлэгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэлд 17,076.5 мянган төгрөг, шатахууны 2,500.0 мянган төгрөг, урсгал засвар болон бусад зардлын 11,098.6 мянган төгрөгийн өглөг үүссэн ба ЭМД-ийн хэлтэстэй тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн

давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Жаргалант сумын Эрүүл мэндийн төв нь 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 136 мэдээллийг бүрэн мэдээлж, 13 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн е-баримтгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал "өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар", Зам, тээврийн хөгжлийн сайдын 390 дугаар тушаал "Жишиг норм батлах тухай" хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Жаргалант сумын Эрүүл мэндийн төвд итгэл үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,649.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,689.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,722.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж, 237.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо.

4.1 Залруулсан алдаа

Зардлын зүйл ангийг буруу сонгосоноор санхүүгийн үр дүнгийн тайланд 1,689.5 мянган төгрөгийг зөрүүтэй илэрхийлсэнийг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1.1. Илрүүлэлт:

Үндэслэлгүй тушаал гарган шагнал, урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн

захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.3 Албан шаардлага Байхгүй.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 774.0 мянган төгрөгийн дутуу баримтаар гүйлгээ хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

1.3 Илрүүлэлт:

Хүнсний материал, шатах тослох материал зарлагадаа НХМаягт БМ-4, БМ-6 маягт ашигладаггүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар"-тай нийцэхгүй байна.

1.4 Өгсөн зөвлөмж:

Хүнсний материал, шатах тослох материалын зарцуулалтад анхан шатны маягтыг бүрэн хөтөлж, баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдлийг хангасан нөхцөлд зарлага гаргаж, санхүүгийн тайланд тусгах.

1.5 Илрүүлэлт:

Өдөрт явбал зохих км, цилиндрийн багтаамжтай холбоотой норм нормативыг зөрчиж 3,948.6 мянган төгрөгийн шатах тослох материал зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дүгээр тушаалтай нийцэхгүй байна.

1.6 Өгсөн зөвлөмж:

Автомашин шатахуун зарцуулалтын хэмжээг туршилт хийж баталгаажуулан, бодит зарцуулалтыг үнэн зөв тодорхойлж, шатахууныг зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын Эрүүл мэндийн төв	5	6,649.1	1	1,689.5	1	237.0	0	0	3	4,722.6